



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 04-ны өдөр

Дугаар 1/02

Эрдэнэт

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 12, 20 дугаар зүйл, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 8.1 дүгээр заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалын 2.2, 3.2, 4.1 дэх заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, бусад холбогдох журам, стандарт, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах болон хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг дүгнэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд явцын хяналт хийх, хагас бүтэн жилээр дүгнэж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



Аймгийн Засаг дарга, ЭМГ, Хувийн хэвшлийн ортой эмнэлэгтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, ЭМГ-аас Медипас төрөлжсөн төв эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулах болон гэрээг дүгнэх ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: Б.Уртнасан –Яаралтай гамшигийн үеийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- М.Ариун-Эрдэнэ-Хүний нөөцийн төлөвлөлт, хангарт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- О.Анхбаяр-Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- А.Баярхүү-Сувилахуй, хөнгөвчлөх тусlamж үйлчилгээний тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Б.Билгүүнээ- Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан
- Н.Мөнгөнцацралт-Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан

Нарийн бичиг: Г.Итгэл –Эрүүл мэндийн статистик, мэдээллийн мэргэжилтэн

ЭМГ-аас Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын цогцолбор, Ногоон ариусгал ТББ, Клиникуудийн холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгуулах болон гэрээг дүгнэх ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: П.Хишгээ –Эх хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- М.Ариун-Эрдэнэ-Хүний нөөцийн төлөвлөлт, хангарт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- А.Баярхүү-Сувилахуй, хөнгөвчлөх тусlamж үйлчилгээний тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Б.Билгүүнээ- Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан
- Θ.Наранзаяа-Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан
- Н.Эрдэнэчимэг-Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, мэдээний сан хариуцсан ажилтан

Нарийн бичиг: Т.Нарантуяа –Уламжлалт анагаах ухааан, сэргээн засах тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газраас Эм ханган нийлүүлэх байгууллагатай хийсэн хамтын
гэрээг дүгнэх ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: Б.Уртнасан- Яаралтай гамшгийн үеийн тусlamж үйлчилгээ хариуцсан

мэргэжилтэн

Гишүүд:

Д.Отондэлгэр- Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн

Ө.Наранзаяа- Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг: О.Анхбаяр-Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын даргын 2021 оны...... сарын ... өдрийн
..... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДТАЙ БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагуудаас хүн амд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй тасралтгүй үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын тогтвортой байдлыг хангах зорилгоор байгуулсан гэрээг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Захиалагч тал Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний биелэлтийн үр дүнг үнэлэхэд энэхүү журмыг баримтлана.

Хоёр. Гэрээг дүгнэхэд баримтлах зарчим

2.1. Монгол улсын хууль тогтоомж, холбогдох дээд шатны байгууллагын гаргасан бүтэц, үйл ажиллагааны стандарт, тушаал, журам, заавар, шийдвэр, урт болон дунд хугацааны төлөвлөлт, хөтөлбөрийг баримтлан ил тод, нээлттэй, хамт олны оролцоог хангасан байна.

2.2. Гэрээний гүйцэтгэлийг дүгнэх аргачлал хэмжигдэхүйц, бодитой, ажлын ачааллыг харгалзсан, ойлгомжтой, тодоохой үр дүнд үндэслэсэн байна.

2.3 Гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтийг гэрээний хавсралтаар баталгаажуулсан байна.

Гурав. Гэрээг дүгнэх ажлын зохион байгуулалт

3.1 Гэрээний биелэлтийг жил бүрийн зургаа, арван хоёрдугаар сарын 20-ны дотор багтаан дүгнэж, дүнг ажлын хэсгийн хурлаар баталгаажуулсан байна.

3.2 ЭМГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг гэрээг дүгнэнэ.

3.3 Гэрээг дүгнэх явцад холбогдох ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнг татан оролцуулж болно.

Дөрөв. Гэрээний биелэлтийг дүгнэх арга аргачлал

Гэрээний биелэлтийг шалгуур үзүүллэлтүүдийн дагуу эхний хагас жил, жилийн эцэст дүгнэх ба үнэлгэн дээр хагас жилийн үнэлгээгээр өгөгдсөн зөвлөмжүүдийн биелэлтийг тооцон нэгтгэн дүгнэнэ.

4.1 Дүгнэх ажлын хэсэг нь хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад шаардлагатай нэмэлт мэдээллийг (үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, түүнийг хэрэгжүүлэхээр зохиосон ажил, хүрсэн үр дүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, өмч, хөрөнгийн ашиглалтын байдал, үр дүнгийн талаар нэмэлт судалгаа) тухайн байгууллага, холбоо /Эм холбоо ба Чандмань-Эрдэнэ холбоо, Клиникийдийн холбоо/-ноос гаргуулсан, ажиллагсад, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч гэрээний биелэлтийг дүгнэхэд ашиглана.

4.2 Гэрээний биелэлтийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам батлах тухай" 422-р тушаал, Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны Эрүүл мэндийн газар түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журамд заасан арга зүй, аргачлалыг үндэслэн дараах байдлаар дүгнэнэ.

"A" буюу "Хангалттай сайн"	90-100 хувь (4.50-5.00 оноо)
"B" буюу "Сайн"	80-89.0 хувь (4.00-4.49 оноо)
"C" буюу "Хангалттай"	70-79.0 хувь (3.50-3.99 оноо)
"D" буюу "Дутагдалтай"	60-69.0 хувь (3.00-3.49 оноо)
"F" буюу "Хангалтгүй"	0-59.0 хувь (0.00-2.99 оноо)

4.3 Захиалагч нь гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа нь "A" үнэлгээтэй дүгнэгдсэн бол эрүүл мэндийн салбарын шагнал урамшуулалт хамруулах, улс, бус нутагт боломжит бүх хэлбэрээр сурталчлан, эмч мэргэжилтнийг алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.4 Үйл ажиллагаа нь тогтвортсон, "B" үнэлгээтэй дүгнэгдсэн бол эмч, мэргэжилтнүүдийг аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас шагнаж, урамшуулах, хамт олныг туршлага судлуулах, сургалтад хамруулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.5 Захиалагч нь "C", үнэлгээтэй дүгнэгдсэн бол ажил сайжруулах хугацаатай үүргийг өгч, биелэлтийг тооцон ажиллана.

4.6 Жилийн эцсийн гэрээний биелэлтээр "D" үнэлгээ авч, ажлын хэсгийн дүгнэлтээр үйл ажиллагаанд тодорхой ахиц гаралгүй гэж үнэлгэдсэн бол тусгай зөвшөөрлийг цуцлана.

4.7 Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс хамтын ажиллагааны гэрээний биелэлтэд сөргөөр нөлөөлсөн гэж ажлын хэсэг дүгнэсэн тохиолдолд холбогдох албан тушаалтан, ажилтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

4.8 Эрүүл мэндийн байгууллага нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд гэрээг цуцлана.